

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/010/НА- СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2026

2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	106,577,158.00	396,202,165.00
МӨНГӨН ХӨРӨНГӨ	106,577,158.00	79,211,744.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	106,577,158.00	79,211,744.00
Төрийн сангийн харилцах	106,577,158.00	79,211,744.00
Бусад хангамжийн материал	0.00	316,990,421.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	106,577,158.00	396,202,165.00
НИЙТ ӨР ТӨЛБӨР	106,577,158.00	396,202,165.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	106,577,158.00	396,202,165.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	106,577,158.00	396,202,165.00
Засгийн газрын хувь оролцоо	106,577,158.00	396,202,165.00
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	106,577,158.00	396,202,165.00
Хуримтлагдсан үр дүн	106,577,158.00	396,202,165.00
Өмнөх үеийн үр дүн	14,996,258.00	106,577,158.00
Тайлант үеийн үр дүн	91,580,900.00	289,625,007.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	106,577,158.00	396,202,165.00

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	479,907,900.00	345,368,800.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,023,000.00	345,368,800.00
Нийтлэг татварын бус орлого	62,023,000.00	5,327,000.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	62,023,000.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,023,000.00	5,327,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,884,900.00	340,041,800.00
Улсын төвлөрсөн төсвөөс	317,884,900.00	
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	317,884,900.00	240,041,800.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутаг малын хөлийн татвар /	100,000,000.00	100,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	388,327,000.00	55,743,793.00
УРСГАЛ ЗАРДАЛ	388,327,000.00	55,743,793.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,327,000.00	55,743,793.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	388,327,000.00	55,743,793.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	91,580,900.00	289,625,007.00

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0	0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	479,907,900.00	345,368,800.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,023,000.00	345,368,800.00
Нийтлэг татварын бус орлого	62,023,000.00	5,327,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	62,023,000.00	5,327,000
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,023,000.00	5,327,000
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,884,900.00	340,041,800.00
Улсын төвлөрсөн төсвөөс		
Орлон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	317,884,900.00	240,041,800.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөв /	100,000,000.00	100,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	479,907,900.00	345,368,800.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	388,327,000.00	372,734,214.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	388,327,000.00	372,734,214.00
Дотоод эх үүсвэрээр	388,327,000.00	372,734,214.00
Бусад хөрөнгө		372,734,214.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-388,327,000.00	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	91,580,900.00	-27,365,414.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,996,258.00	106,577,158.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	106,577,158.00	79,211,744.00

1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	14,996,258.00	14,996,258.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,996,258.00	14,996,258.00
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	106,577,158.00	106,577,158.00
2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	106,577,158.00	106,577,158.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	106,577,158.00	106,577,158.00
Тайлант үеийн үр дүн	289,625,007.00	289,625,007.00
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	396,202,165.00	396,202,165.00

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	343,820,100.00	340,041,800.00	3,778,300.00	98.90
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	243,820,100.00	240,041,800.00	3,778,300.00	98.45
Орон нутгийн төсвөөс санхүүжих /Малын тоо толгойн албан татвар/	100,000,000.00	100,000,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний орлого	17,894,000.00	5,327,000.00	12,567,000.00	29.77
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	8,104,000.00	5,327,000.00	2,777,000.00	65.73
Хандив, тусламжийн орлого	9,790,000.00		9,790,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	361,714,100.00	345,368,800.00	16,345,300.00	95.48

НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	450,397,200.00	372,734,214.00	77,662,986.00	82.76
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	450,397,200.00	372,734,214.00	77,662,986.00	82.76
Бусад хөрөнгө	450,397,200.00	372,734,214.00	77,662,986.00	82.76
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(88,683,100.00)	(27,365,414.00)	(61,317,686.00)	12.72
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88,683,100.00	106,577,158.00	(17,894,058.00)	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		79,211,744.00	(79,211,744.00)	

2. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Сумын ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлж бүрэн хэрэгжсэн, ашиглаж байгаа төсөл арга хэмжээний эзэмшигчийг сумын ИТХ-аар тогтоож, нягтлан бодох бүртгэлд тусгах;
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний заалтуудыг хуульд нийцүүлэх, хийгдэх ажлыг гэрээнд зөв нэршлээр тусгах, ажлыг хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй тохиолдолд гэрээнд заасан алдангийг тооцож байх;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэхдээ завсрын аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийг цаашид анхаарч, давтан гаргахгүй ажиллах нь зүйтэй байна.

3. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 50,000.0 мянган төгрөгийн нэг төсөл арга хэмжээг хүлээн аваагүй зөрчилд албан шаардлага өгснийг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитын системд хэрэгжилтийг оруулсан байна.

Завсрын аудитыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон 2025 оны 11 дүгээр сард гүйцэтгэж, аудитаар 245,388.7 мянган төгрөгийн 15 зөрчил илэрснээс жилийн эцсийн аудитаар зөрчил арилсан эсэхийг шалгахад дараах 15,119.6 мянган төгрөгийн дараах 5 зөрчлийг арилгасан гэж үнэлсэн. Үүнд:

1. Acolous санхүүгийн программд 715.0 мянган төгрөгөөр ОНХС-ийн санхүүгийн тайланг бэлтгэх бааз үүсгэсэн байхад санхүүгийн тайланг программд бүртгээгүй зөрчлийг арилган, санхүүгийн программд гүйлгээнүүдийг бүртгэсэн байна.
2. Иргэдээс санал авсан баримтыг ирүүлээгүй зөрчлийн мөрөөр Иргэдээс авсан баримтыг багийн Засаг дарга нар журмын дагуу нэгтгэж өгөөгүй байсныг нөхөж бүрдүүлсэн байна.
3. Иргэн С.Алтанчимэгтэй 2025.01.30-ны өдөр байгуулсан 01 тоот гэрээнд 12,000.0 мянган төгрөгөөр өвс худалдан авахдаа тоо ширхэг, өвсний нэг бүрийн үнийг тодорхой тусгаагүй зөрчлийг арилгаж, зарлагын баримт, ажил хүлээн авах актад тоо ширхгийг тусгасан байна.
4. Баяр наадмын зардалд Б.Мөнхбатад олгосон 3,119.6 мянган төгрөгийн санхүүгийн анхан шатны баримт байхгүй байсан зөрчлийг арилгаж, баримтыг санхүүгийн баримтад хавсаргасан байна.
5. ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд Төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах /Эрүүл мэнд/, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх гэсэн 2 төсөл арга хэмжээнээс бусад ТАХ-ний мэдээллийг оруулаагүй байсан зөрчлийг арилгаж, системд мэдээллүүдийг оруулсан байна.

Завсрын аудитаар илэрсэн дээрх зөрчлөөс жилийн эцсийн санхүүгийн тайланд 172,983.2 мянган төгрөгийн 4 алдааг аудитаар илэрсэн зөрчилд бүртгэж, 32,962.0 мянган

төгрөгийн 2 зөрчлийг нэгтгэж, 1 зөвлөмж өгч, 122,021.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч, 18,000.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг санхүүгийн тайланд авлагаар залруулга хийсэн болно.

4. Ерөнхий чиглэлийн судалгааны талаар

ҮАГ-аас нэгдсэн журмаар авч байгаа ерөнхий чиглэлийн 8 судалгаанаас хамааралтай дараах 1 судалгааг гаргаж ажлын баримтад хавсаргав.

- Мэдээллийн технологийн зардлын тухайд: Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийг "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "ACOLOUS" программыг 2025 оноос эхлэн ашигласан, тухай жилийн төсөв хүрэлцээгүйн улмаас тус аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, программын төлбөрийг төлөөгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгээгүй.

Аудитаар нийт 700,903.9 мянган төгрөгийн 5 зөрчил зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.1. Албан шаардлага

1. Жинст сумын Засаг дарга сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийтийн биеийн тамирын талбай байгуулах төсөл арга хэмжээг батлагдсан зураг төсөвгүйгээр "Нью бест хаус" ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр 122,021.2 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний 2.4-т заасан 99,909.5 мянган төгрөгийн санхүүжилтийг аж ахуйн нэгжид бүрэн олгосон байхад ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ны дотор хүлээлгэн өгөх хугацаанд бүрэн гүйцэтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 29 дүгээр зүйлийн 29.4 дэх "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Жинст сумын Засаг дарга, "Нью бест хаус" ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан гэрээний 1.5-т "Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох Нийтийн биеийн тамирын талбайн ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ны дотор хийж дуусгаж ажлыг хүлээлгэж өгөхөөр гэрээг байгууллаа" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нью бест хаус" ХХК-аар ажлыг чанартай бүрэн хийлгүүлж, мэргэжлийн байгууллагын хяналтыг хэрэгжүүлэн, улсын комиссоор хүлээн авах албан шаардлага өгөх

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 339,001.8 мянган төгрөгийн орлогын 12 гүйлгээ, 213,880.9 мянган төгрөгийн 18 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсныг завсрын аудитаар арилгахыг зөвлөсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг нөхөн байршуулах, төсвийн захирагчаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага өгөх

3. Тайлант онд “Инж геотек” ХХК-тай сумын Засаг дарга 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр “Инженер хайгуулын судалгааны ажил гүйцэтгэх гэрээ”-г 3,000.0 мянган төгрөгөөр байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон байхад тус аж ахуйн нэгжээс мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хянуулж, баталгаажуулсан судалгааны тайланг хүлээн аваагүй байна.

Энэ нь Геодези, зураг зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь “Геодези, зураг зүйн улсын хяналтыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Жинст сумын Засаг дарга, “Инж геотек” ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан гэрээний 3.2-т “Гэрээгээр хүлээсэн судалгааны ажил үүргийг өөрийн эд хөрөнгө, техник, багаж хэрэгслээр гүйцэтгэх ба ажлын үр дүнг захиалагчид 2025 оны 03 дугаар сарын 03-ны дотор хүлээлгэн өгнө” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: “Инж геотек” ХХК-ийн гүйцэтгэсэн инженер хайгуулын судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагын хяналтыг хэрэгжүүлэн хүлээн авах, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлага өгөх

4. Жинст сумын Засаг дарга “Их Богдын ундарга” ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр гэрээ байгуулж, 13,000.0 мянган төгрөгөөр “Мал угаалгын ванн барих гэрээ” байгуулж, 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ажлыг дуусгаж хүлээлгэн өгөхөөр зааж, гэрээний 2.4-т заасны дагуу урьдчилгаа санхүүжилтийн 9,100.0 мянган төгрөгийг 2025.09.22-ны өдөр авсан бөгөөд аж ахуйн нэгж гэрээний үүргээ биелүүлж ажлыг хугацаанд нь хүлээлгэж өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Жинст сумын Засаг дарга, “Их богдын ундарга” ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан гэрээний 1.5-т “гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох Мал угаалгын ванн барих гэрээт ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор хийж дуусгаж ажлыг хүлээлгэж өгөхөөр гэрээг байгууллаа” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: "Их Богдын ундарга" ХХК-аар ажлыг чанартай, бүрэн гүйцэтгүүлж, мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгэж, улсын комиссоор хүлээн авах, заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлага өгөх

Тайлант онд сумын ИТХ-аар баталсан төсөл хөтөлбөр, ТЭЗҮ зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээний хүрээнд "Геодезийн хэмжилт, зураглалын ажил гүйцэтгэх гэрээ"-г тусгай зөвшөөрөлгүй "Эбба Лэгдэн Констракшн" ХХК-тай 2025.02.17-ны өдөр байгуулж, 10,000.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Геодези, зураг зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх "Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэн дараах үүрэгтэй: геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан байх", 8 дугаар зүйлийн 8.2 дахь "Геодези, зураг зүйн улсын хяналтыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид сумын ИТХ-аар баталсан төсөл хөтөлбөр, ТЭЗҮ зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогчид талархал илэрхийлье.

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Тайлант онд сумын ИТХ-аар баталсан "Геодезийн хэмжилт, зураглалын ажил гүйцэтгэх гэрээ"-г сумын засаг дарга "Эбба Лэгдэн Констракшн" ХХК-тай 2025.02.17-ны өдөр байгуулж, 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба тухайн аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрөлгүй бөгөөд тус ажлыг эрх бүхий байгууллагаар хянуулж, хүлээлгэн өгөөгүй байна.	1	10,000.0			1.0	10,000.0						
Жинст сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийтийн биеийн тамирын талбай байгуулах 8 дугаартай гэрээг сумын Засаг дарга "Нью бест хаус" ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байгуулж, 122,021.2 мянган төгрөгийн тус ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ны дотор хүлээлгэн өгөхөөр заасан бөгөөд гэрээний 2.4-т заасан урьдчилгаа, дундын санхүүжилтийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжид бүрэн олгосон байхад гэрээний үүргээ биелүүлж, ажлыг хүлээлгэн өгөөгүй байна.	1	122,021.2			1	122,021.2						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 339,001.8 мянган төгрөгийн орлогын 12 гүйлгээ, 213,880.9 мянган төгрөгийн 18 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсныг завсрын аудитаар арилгахыг зөвлөсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	552,882.7			1	552,882.7						

А		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Тайлант онд "Инж геотек" ХХК-тай сумын Засаг дарга 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр "Инженер хайгуулын судалгааны ажил гүйцэтгэх гэрээ"-г 3,000.0 мянган төгрөгөөр байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон байхад тус аж ахуйн нэгжээс мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хянуулж баталгаажуулсан судалгааны тайланг хүлээн аваагүй байна.		1	3,000.0				1	3,000.0						
Жинст сумын Засаг дарга "Их Богдын ундарга" ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр гэрээ байгуулж, 13,000.0 мянган төгрөгөөр "Мал угаалгын ванн барих гэрээ" байгуулж, 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ажлыг дуусгаж хүлээлгэн өгөхөөр зааж, гэрээний 2.4-т заасны дагуу урьдчилгаа санхүүжилтийн 9,100.0 мянган төгрөгийг 2025.09.22-ны өдөр авсан бөгөөд аж ахуйн нэгж гэрээний үүргээ биелүүлж ажлыг хугацаанд нь хүлээлгэж өгөөгүй байна.		1	13,000.0			1	13,000.0							
Дүн		5	700,903.9	-	-	5	700,903.9	-	-	-	-	-	-	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр	1		1					
	НИЙТ	1		1					

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 153/9/A056.0228/БНА
2026/025/НА - СТА - ТУЗ

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жинст сумын Засаг дарга сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийтийн биеийн тамирын талбай байгуулах төсөл арга хэмжээг батлагдсан зураг төсөвгүйгээр "Нью бест хаус" ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр 122,021.2 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний 2.4-т заасан 99,909.5 мянган төгрөгийн санхүүжилтийг аж ахуйн нэгжид бүрэн олгосон байхад ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ны дотор хүлээлгэн өгөх хугацаанд бүрэн гүйцэтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 29 дүгээр зүйлийн 29.4 дэх "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Жинст сумын Засаг дарга, "Нью бест хаус" ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан гэрээний 1.5-т "Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох Нийтийн биеийн тамирын талбайн ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ны дотор хийж дуусгаж ажлыг хүлээлгэж өгөхөөр гэрээг байгууллаа" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. "Нью бест хаус" ХХК-аар 122,021,159 (Нэг зуун хорин хоёр сая хорин нэгэн мянга нэг зуун тавин есөн) төгрөгийн ажлыг чанартай бүрэн хийлгүүлж, мэргэжлийн

6426090476


байгууллагын хяналтыг хэрэгжүүлэн, улсын комиссоор хүлээн авах, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шийдвэрийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн ФАС системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг дарга Б.Алтанхуяг, ЗДТГ-ын дарга 3.Цэрэндорж нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ
Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 156/2/A0560238/5
2026/070/НА-СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 339,001,800 (Гурван зуун гучин есөн сая нэг мянга найман зуун) төгрөгийн орлогын 12 гүйлгээ, 213,880,893 (Хоёр зуун арван гурван сая найман зуун наян мянга найман зуун ерэн гурав) төгрөгийн 18 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсныг завсрын аудитаар арилгахыг зөвлөсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 339,001,800 (Гурван зуун гучин есөн сая нэг мянга найман зуун) төгрөгийн орлогын 12 гүйлгээ, 213,880,893 (Хоёр зуун арван гурван сая найман зуун наян мянга найман зуун ерэн гурав) төгрөгийн 18

6426090462

гүйлгээг нөхөн мэдээлэх, шийдвэрийн хэрэгжилтийг гүйцэтгэл нийцлийн системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг дарга Б.Алтанхуягт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 157/3/АОСБ 0238/БТН
2026/010/НА-СТА-ТМБ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд "Инж геотек" ХХК-тай сумын Засаг дарга 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр "Инженер хайгуулын судалгааны ажил гүйцэтгэх гэрээ"-г 3,000,000 (Гурван сая) төгрөгөөр байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон байхад тус аж ахуйн нэгжээс мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хянуулаагүй, баталгаажуулсан судалгааны тайланг хүлээн аваагүй байна.

Энэ нь Геодези, зураг зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь "Геодези, зураг зүйн улсын хяналтыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Жинст сумын Засаг дарга, "Инж геотек" ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан гэрээний 3.2-т "Гэрээгээр хүлээсэн судалгааны ажил үүргийг өөрийн эд хөрөнгө, техник, багаж хэрэгслээр гүйцэтгэх ба ажлын үр дүнг захиалагчид 2025 оны 03 дугаар сарын 03-ны дотор хүлээлгэн өгнө" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага

6426090464

өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. "Инж геотек" ХХК-ийн гүйцэтгэсэн инженер хайгуулын судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагын хяналтыг хэрэгжүүлэн хүлээн авах, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шийдвэрийн хэрэгжилтийг гүйцэтгэл нийцлийн системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг дарга Б.Алтанхуяг, ЗДТГ-ын дарга З.Цэрэндорж нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:



Б.ДОЛЖМАА

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 158/4/АУСЗОЗСЗТ/БМА
2026/0101/АА.СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жинст сумын Засаг дарга "Их Богдын ундарга" ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр гэрээ байгуулж, 13,000,000 (Арван гурван сая) төгрөгөөр "Мал угаалгын ванн барих гэрээ" байгуулж, 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ажлыг дуусгаж хүлээлгэн өгөхөөр зааж, гэрээний 2.4-т заасны дагуу урьдчилгаа санхүүжилтийн 9,100,000 (Есөн сая нэг зуун мянган) төгрөгийг 2025.09.22-ны өдөр авсан бөгөөд аж ахуйн нэгж гэрээний үүргээ биелүүлж ажлыг хугацаанд нь хүлээлгэж өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Жинст сумын Засаг дарга, "Их богдын ундарга" ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан гэрээний 1.5-т "гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох Мал угаалгын ванн барих гэрээт ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор хийж дуусгаж ажлыг хүлээлгэж өгөхөөр гэрээг байгууллаа" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан



6426090468

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Их Богдын ундарга" ХХК-аар гэрээнд заасан 13,000,000 (Арван гурван сая) төгрөгийн ажлыг чанартай, бүрэн гүйцэтгүүлж, заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шийдвэрийн хэрэгжилтийг гүйцэтгэл нийцлийн системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг дарга Б.Алтанхуяг, ЗДТГ-ын дарга З.Цэрэндорж нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:
 БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  **Б.МӨНХБАТ**
 АХЛАХ АУДИТОР:  **Б.ДОЛЖМАА**

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 160/5/А0580238/БНА
2026/0357-НА -СТА -ТУС

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сумын ИТХ-аар баталсан төсөл хөтөлбөр, ТЭЗҮ зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээний хүрээнд "Геодезийн хэмжилт, зураглалын ажил гүйцэтгэх гэрээ"-г тусгай зөвшөөрөлгүй "Эбба Лэгдэн Констракшн" ХХК-тай 2025.02.17-ны өдөр байгуулж, 10,000,000 (Арван сая) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Геодези, зураг зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх "Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэн дараах үүрэгтэй: геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй


6426090474

байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ**
НЬ:

1. Цаашид сумын ИТХ-аар баталсан төсөл хөтөлбөр, ТЭЗҮ зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹³.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг дарга Б.Алтанхуяг, ЗДТГ-ын дарга Ц.Цэрэндорж нарт даалгав¹⁴.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН¹⁵:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ
АХЛАХ АУДИТОР Б.ДОЛЖМАА



¹³ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

¹⁴ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

¹⁵ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно